



"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТОВЧИЛСОН ҮГС

БОАЖГ	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
БОАЖЯ	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
БОМТ	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БОНЕУ	БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ
БОННУ	БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
ХАБЭА	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ
ХЭМАБ	ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	1
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
ОРШИЛ.....	4
1.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ.....	4
1.2. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН 5	
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ	6
2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	6
2.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	7
2.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ.....	9
2.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ.....	12
БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	14
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	17
4.1. УУР АМЬСГАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛСЭЭС ҮҮСЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ	17
4.2. АГААРЫН ЧАНАРЫН ХҮЧИН ЗҮЙЛСЭЭС ҮҮСЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	17
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	20
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	20
ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ГОЛ ШААРДЛАГА	20
5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
5.1.1. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	22
5.1.2. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	26
5.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 27	
5.1.4. Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	27
5.1.5. Газрын тосны бүтээгдэхүүний эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	27
5.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	31
5.1.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	34
5.1.8. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал..... Error! Bookmark not defined.	
5.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	35
5.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	39
5.3.1 Хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	40
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	7
Хүснэгт 2. Агуулахын хадгалах савуудын хүчин чадал	9
Хүснэгт 3. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ.....	18
Хүснэгт 4. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа /мян.төг/.....	20



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 5. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал /мян.төг/	21
Хүснэгт 6. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	23
Хүснэгт 7. Ногоон байгууламжийг нөхөн сэргээлтийн хэмжээний төлөвлөгөөний зардал	26
Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	28
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	31
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	33
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил	34
Хүснэгт 12. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал	
Хүснэгт 13. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	36
Хүснэгт 14. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	38
Хүснэгт 15. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч	39
Хүснэгт 16. Төсөлтэй холбоотой хууль тогтоомжууд	40
Хүснэгт 17. Монгол улсын байгаль орчны чанарын норм стандарт	41

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн одоогийн зураг	7
Зураг 2. Төслийн талбайн байр зүйн зураг	8
Зураг 3. Бохирдсон хур борооны ус зайлуулах цооног	10
Зураг 4. Ачих, буулгах талбай	11
Зураг 5. Агуулахын гүний худгийн байршил	13
Зураг 6. Гал унтраах хэрэгсэл	29
Зураг 7. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ	30
Зураг 8. Хог хаягдлын цэгийн шийдэл	32
Зураг 9. Хог хаягдлын цэгийн хэмжээс	33



БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ОРШИЛ

"Петровис" ХХК нь анх 1997 онд газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэнгийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба 2004 онд Монгол улсын Засгийн газраас зарласан олон улсын тендерт шалгарч, газрын тосны салбарын ууган компани болох "НИК" ХК-ийг нэгтгэн үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Одоогоор "Петровис" ХХК нь Монгол орон даяар 400 гаруй шатахуун түгээх станц, 2300 гаруй ажилтан, 9 агуулахтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний зах зээлийн 28 хувийг эзэлж байна.

Тус байгууллага нь стратегийн чухал ач холбогдол бүхий газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан авто тээврийн хэрэгслээс ялгарах агаарын бохирдлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулан хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, агаарын чанарт эерэг нөлөөтэй, экологийн өндөр ангилал бүхий "Евро-5" стандартын шатахууныг 2016 онд салбартаа анх удаа нэвтрүүлсэн.

Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний "Экологийн бүтээмж" ХХК-ын тусламжтай "Газрын тосны бүтээгдэхүүний агуулах" төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г БОНХСайдын 2019 оны 10 дугаар 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" болон бусад холбогдох дүрэм, журам, стандартад нийцүүлэн гүйцэтгэв.

1.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй "Газрын тосны бүтээгдэхүүний агуулах" төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг 2024 онд "ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ" ХХК хийж гүйцэтгэсэн.

Бид бүхэн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" болон "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-г удирдлага болголоо.



1.2. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН

Ажлын зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- a) Ажиллагсад бүх байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, үр чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
- b) Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж хамгаална.
- c) Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
- d) Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн БОМТ-тэй танилцан баталж, төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох ба жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, БОАЖГ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй ба тэдгээрт холбогдох мэдээлэл ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

Бүрэлдэхүүн хэсэг: БОМТ-г доорх үндсэн 2 бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилан авч үзэв. Үүнд:

- a) Байгаль орчны менежмент төлөвлөгөө: Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- b) Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.



БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Газрын тосны бүтээгдэхүүний агуулах

Төслийн зорилго: Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Газрын тосны бүтээгдэхүүний агуулах нь хэрэглэгчдийг газрын тосны бүтээгдэхүүнээр хангах зорилготой.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

Петровис ХХК нь анх 1997 онд газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэнгийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба 2004 онд Монгол улсын Засгийн газраас зарласан олон улсын тендерт шалгарч, газрын тосны салбарын ууган компани болох НИК ХХК-ийг нэгтгэн үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Одоогоор Петровис ХХК нь Монгол орон даяар 400 гаруй шатахуун түгээх станц, 2300 гаруй ажилтан, 9 агуулахтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа ба Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний зах зээлийн 28 хувийг эзэлж байна.

Тус байгууллага нь стратегийн чухал ач холбогдол бүхий газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан авто тээврийн хэрэгслээс ялгарах агаарын бохирдлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулан хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, агаарын чанарт эерэг нөлөөтэй, экологийн өндөр ангилал бүхий "Евро-5" стандартын шатахууныг 2016 онд салбартаа анх удаа нэвтрүүлсэн.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь шатахууныг ОХУ-аас импортолж, хэрэглэгчдэд хүргэхдээ хадгалалт, тээвэрлэлтийн хамгийн найдвартай тогтолцоог мөрдөн ажиллаж ирлээ. Өнөөдрийн байдлаар Стандарт хэмжилзүйн газрын баталгаатай, 24 цагийн хяналтын GPS системтэй 300 автоцистерн ажиллаж, чанартай шатахууныг тээвэрлэн хэрэглэгчдэд хүргэж байна. Түүнчлэн бүтээгдэхүүнээ чанарын баталгаатай хүргэх үүднээс агуулахуудад байрлах 9 лабораторид шинжлэн баталгаажуулж байна.

- Шатахууныг хүлээн авахаас хэрэглэгчид хүрэх хүртэл хадгалалт, тээвэрлэлт, ачилт/ буулгалтын бүх шат дамжлагыг технологи, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн баг гүйцэтгэж байна.
- Хадгалалт, нөөцийн хамгийн том сүлжээ (3-6 төрлийн шатахуун хадгалах боломжтой, 200 сая гаруй литрийн багтаамж бүхий 36 газрын тосны бүтээгдэхүүний агуулах)
- Стандарт хэмжилзүйн газрын баталгаатай, 24 цагийн хяналтын GPS системтэй 300 автоцистерн
- Өөрийн агуулахуудад байрлах 9 лаборатори



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Төсөл хэрэгжүүлэгч нь хамгийн чанартай бүтээгдэхүүнийг, хамгийн өргөн сүлжээгээр буюу орон даяар байрлах 400 орчим шатахуун түгээх станцаар дамжуулан 24/7 цагийн горимд найдвартай, тасалдалгүй хүргэж байна.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага: НИК ХХК

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	"НИК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011250037
Регистрийн дугаар	2075261
Улсад бүртгүүлсэн	2005.10.22
Үйл ажиллагааны чиглэл	<ul style="list-style-type: none"> • Нефть, нефтийн бүтээгдэхүүн шингэрүүлсэн хийн гадаад, дотоод худалдаа • Нефтийн тоног төхөөрөмжийн худалдаа, засвар үйлчилгээ • Автомашины засвар үйлчилгээ Агуулах, шатахуун түгээх станц барих, засварлах
Хаяг	Ерөнхий сайд Амарын гудамж-7 Петровис компанийн байр Сүхбаатар дүүрэг Улаанбаатар хот 14201, Монгол улс
Утас	+976 11-330505
Холбогдох мэргэжилтний мэдээлэл	Өмнөговь аймгийн НХС-ын ХАБЭА-н инженер Б.Саранцэцэг Утас: 88977007 Цогтцэций Агуулахын ХАБЭА-н инженер Г.Ерөөлт 86920136

2.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 1 баг, Цогтцэций сумаас зүүн хойно 13км-т төмөр зам дагуу төслийн талбай оршиж байна.



Зураг 1.Төслийн талбайн одоогийн зураг



"НИК" ХХК-ийн ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 2. Төслийн талбайн байр зүйн зураг



2.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Газрын тосны бүтээгдэхүүний агуулах нь Аи92, Дт, Евро Дт төрлийн шатахуун хүлээн авч зориулалтын саванд шатахууныг нөөцлөн хадгалдаг. Нийт 5 ширхэг ил босоо савтай. Тус савнууд нь хаалт крант болон амьсгалах клапан, цэвэрлэгээний люк, сифон хаалт, галын хөөсний камер, хөргөлтийн шугам зэрэг тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.

Хүснэгт 2. Агуулахын хадгалах савуудын хүчин чадал

Багтаамж	Зориулалт
75 м ³ 2ш	ДТ,Аи-92, еДТ, еАИ-92
1000 м ³ 3ш	
2000 м ³ 6ш	

- Агуулах нь нэгэн зэрэг 2 автоцистерн хүлээн авах технологийн шийдэлтэй байна.
- Агуулах нь Аи-92, еАи-92, Дизель, евро дизель түлш төрлийн шатахуунуудад зориулалтын тоног төхөөрөмжөөр шатахууны чанар байдалд шинжилгээ хийдэг.

Шатахууныг нөөцлөн хадгалах сав, савны парк:

Энэ байгууламж нь шатахууныг хүлээн авч хадгалах, тээврийн хэрэгслийг шатахуунаар цэнэглэхэд байнгын нөөц бий болгох зориулалттай барилга байгууламжийн цогцолбор юм.

Савны үндсэн хийцийн ашиглалтын нөхцөл нь 2000 Па даралт, 25 Па сийрэгжилт, 8 баллын газар хөдлөлийн чичирхийлэл болон -400С-ээс +400С температурын орчинд тэсвэртэй.

Шатахуун хадгалах ган савны ерөнхий шаардлагыг MNS 4628-98-д заасны дагуу тогтооно. ШТМ хадгалах, нөөцлөх сав нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Техникийн шаардлага хангаж тэгш, зөв суурилагдсан, өнгө будаг шинэ галын, хөдөлмөр хамгааллын тэмдэглэл хийгдсэн, дугаарлагдсан байна.
- Сав нэг бүрийн үндсэн өндрийг тогтоож, жил бүр энэ хэмжээг хянан баталгаажуулж ажилладаг.
- Савны тоноглолууд (амьсгалах клапан, хэмжих хэрэгслүүд, хлопушка, хаалт, арматур, галын хэрэгсэл) бүрэн хэвийн ажиллагаатай байна.
- Сав нь нэвчилт шүүрэлтгүй, битүүмжлэл сайтай байна.
- Техник технологийн дагуу дамжуулах хоолойтой холбогдсон, орлого зарлага хийх боломж хангагдсан, шугам хоолой, холболтууд бүрэн битүүмжлэгдсэн байна.
- Бүтээгдэхүүн хадгалах савнаас зарлагын хоолойгоор гарахгүй үлдэх үлдэгдлийн хэмжээг сав нэг бүрээр гаргасан байх ба энэхүү хэмжээг төлөвлөлтөд ашиглана.
- Техник ашиглалтын паспорт бүрэн хөтлөгдсөн байна.
- Сав тус бүрд эрх бүхий байгууллагаар хийлгэж батлуулсан оноолтын хүснэгттэй байх, савны багтаамжид нөлөөлөхүйц хонхорхой, хэв гажилтгүй байх ёстой.

- Давхар болон дан ханатай савны гэмтлийг илрүүлэх боломжоор хангасан байх бөгөөд 5 жил тутамд саванд металл хийцийн ашиглалтын нөөцийн шалгалтыг эрх бүхий байгууллагаар хийлгэж уг савыг цаашид ашиглах зөвшөөрлийг албан ёсоор авсан байна.

Шатахуунаар бохирдсон хур борооны усыг зайлуулах цооног:

Шатахуун хадгалах агуулах нь Монгол улсын стандарт, агуулахын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлагын дагуу бохир хуримтлуулах цооногтой байх ёстой байдаг. Дээр дурдсан нормд заасны дагуу бохир ус цуглуулах талбай нь нефть бүтээгдэхүүний агуулахын талбайд асгарсан шатахуунаар бохирдсон хур борооны усыг зайлуулах, цуглуулах цооног юм. Энэ нь хамгийн том савыг нэг удаа усаар нэг цаг тасралтгүй шүршихэд үүсэх усыг цуглуулахад хүрэлцэхүйц бөгөөд мөн хамгийн том савны багтаамжаас 15%-иар их байхаар буюу 800м³ багтаамжтай байхаар шийдэж өгсөн.



Зураг 3. Бохирдсон хур борооны ус зайлуулах цооног

Тус газрын тосны бүтээгдэхүүний агуулахын хувьд агуулахын нийт талбайн 70% хатуу хучилттай, шатахуун ачих, буулгах талбай нь шатахуун болон дизель асгарах үед энэ нь хөрсөнд шууд шингэх аюул багатай, асгарсан бүтээгдэхүүнийг ус болон хур борооны усаар угаагдаад гарах бохирыг ууршуулах талбайд очих байдлаар шугам хоолойгоор холбосон байна. Бохирдсон хур борооны ус зайлуулах шугамыг дээрх зургаас харах боломжтой ба тус шугамаар бохирдсон хур борооны ус дамжин цооногт орж цаашлан ууршуулах талбайд хуримтлагддаг байхаар зохицуулжээ. Цооногт хуримтлагдсан бохир усыг бохир соруулан ачилт хийлгэж байх.

Технологийн шугам хоолой

Технологийн хоолойг газрын тосны бүтээгдэхүүнд ашиглахад зөвшөөрөгдсөн, ердийн ган хоолойгоор угсрах ба холбох хэрэгсэл нь ган хоолойн шинж чанараас дутуугүй үзүүлэлт бүхий гангаар хийгдсэн байна. Сав болон шатахууны шугам хоолойн бүх хаалт, арматурууд технологийн хоолойн ажлын дээд даралтад ажиллахаар тооцогдсон байна. Шугам хоолойг угсарч дууссаны дараа ажлын даралтыг 1.25 дахин буюу 0.9 МПа даралтыг 5 минутын туршид өгч шалгах ба дараа нь ажлын даралтын хэмжээнд бууруулан шалгалтыг үргэлжлүүлнэ.

Технологийн шугам хоолойг ил угсрах нь шугамын алдагдал хяналт тавих засвар хийхэд тохиромжтой байдаг. Мөн хоолойг нарны үйлчлэлээр хэт халахаас сэргийлэх, зэврэлтээс хамгаалах зориулалтын цайвар өнгийн будгаар будсан байна.

Галын усны нөөцийн сав

Галын усны нөөцийн савыг шатахуун хадгалах сав паркын талбайн баруун талд байрлуулсан.

Шатахуун ачих /буулгах/ байгууламж

Газрын тосны бүтээгдэхүүнийг 6-н гар бүхий 3-н ширхэг ачих төхөөрөмжөөр дамжуулан нэгэн зэрэг автоцистернд ачна. Бөөний ачилт хийх талбай нь саравчтай, хатуу хучилттай хийгдэх юм.



Зураг 4. Ачих, буулгах талбайн хийгдэж буй явцын зураг

Шатахуун ачихад:

- Тухайн өдөрт зарлага гаргах савны дугаарыг зохих хүмүүст мэдэгдэж чанарын шинжилгээ хийлгүүлэн ачилт эхлэхээс өмнө паспортуудыг нь авсан байна. Эрх бүхий хүмүүсийн баталсан ачилтын даалгавар, хуваарийг баримтлан эд хариуцагч нар нь аль савнаас ямар төрлийн бүтээгдэхүүнийг хэдий хэмжээтэй ачихыг урьдчилан төлөвлөсөн байна.



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Бүтээгдэхүүн тээвэрлэхээр ирсэн автоцистернүүдийн галын аюулгүйн шаардлагыг хангаж байгаа эсэхийг холбогдох үүрэг бүхий хүмүүс, торхны бүрэн бүтэн байдал, баталгаажилт, цэвэрлэгээ, ариун цэвэр, бичиг баримтын бүрдэлтийг эд хариуцагч нар тус шалгаж ачилтад орох зөвшөөрөл олгож, дараалалд оруулан, оч баригч олгоно. Зөрчилтэй автоцистернд ачаа ачихыг хориглож, замын хуудсанд нь тэмдэглэн автоцистернийг буцаана.
- Эд хариуцагч нь тогтоосон (дараалал, торхны багтаамжийн гэрчилгээ, замын хуудас, үнэмлэх) хуваарийн дагуу ачигдсан ШТМ-д чанарын паспорт болон зарлагын падааныг жолоочид хүлээлгэн өгнө.
- Хэрэв торхонд нэвчилт, шүүрэлт болон бусад гэмтлүүд үүссэн байвал уг автоцистернийг замд гарахыг хориглож, өөрийн байгууллагын холбогдох хүмүүст мэдэгдэн, шалгуулж ачааг буцаан буулгуулах арга хэмжээг авхуулна.
- Нефтийн бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгсэлд ачуулах болон тээвэрлэхэд гарах хэвийн хорогдлыг эрх бүхий байгууллагаас гаргасан журмын дагуу тооцоолно.

Шатахуун тээвэрлэхэд:

- Хөдөлгүүр нь хэт их халсан тээврийн хэрэгслийг агуулахад нэвтрүүлэхгүй
- Тээвэрлүүлэгч нь автоцистерн, чиргүүлийг ачаанд оруулахын өмнө үзлэг хийж MNS 5310-2011 стандартын шаардлага хангасан нөхцөлд ачаа олгоно.
- Ачилтын хувийн жинг хэмжиж, зарлагын падаанд бичилт хийн жолоочид хүлээлгэн өгнө.
- Тээвэрлэгч нь энэхүү стандартын шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр ачааг тээвэрлэх бөгөөд зориулалтын бус газарт ачаатайгаар удаан хугацаагаар зогсох /хоноглох/-ыг хориглоно.
- Тээвэрлэлтийн явцад гарсан хохирол зөрчлийг тээвэрлэгч бүрэн хариуцна.
- Чанарын паспортад бүтээгдэхүүний 20 градус дахь хувийн жинг тэмдэглэнэ.

Шатахуун болон дизель хадгалах

Газрын тосны ба түүний бүтээгдэхүүнийг босоо хэлбэрийн ган саванд хадгалдаг. Босоо савны хийц тус бүрийн /дээвэр, хана, шал/ гангийн зузаан болон хатуулгийн хэмжээ ба гагнуурын оёдлын битүүмжлэл нь ашиглалтын шаардлага хангаж ашиглах боломжтой нь батлагдан гарсан байна.

2.4. ТӨСЛИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Газар ашиглалт: Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Өмнөговь аймгийн Цогцэций сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах ба талбай нь нийт 30000 мкв талбайг хамарна.

Тус агуулах нь Өмнөговь аймгийн Засаг даргын 2023 оны А/442 дугаар захирамжаар 30000 мкв талбайг Нефтийн агуулахын зориулалтаар эзэмшдэг.

Цахилгаан хангамж: Агуулах нь төвийн цахилгааны нэгдсэн сүлжээнд холбогдсон.

Зам харилцаа: Гадна зам талбайн орчин сайтай. Төмөр замтай холбогдсон, агуулахын гадна талд хатуу хучилттай автомашины зогсоол шийднэ.



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Халаалт: Агуулахын ажилчдын байр, харуулын байр нь зориулалтын цахилгаан халаалтаар хална.

Усан хангамж: Гүний худагтай, ажилчид баллонтой зөөврийн усаар усаа хангана /Зураг 5/

Зураг 5. Агуулахын гүний худгийн байршил





"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Газрын тоосны бүтээгдэхүүний агуулахын байгаль орчны төлөв байдлыг доор үзүүлэв.

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	
Газрын гадарга, байр зүй	Өмнөговь аймгийн Цогтцэций сум анх 1924 онд байгуулагдсанаас хойш 2024 онд түүхт 100 жилийн ойгоо тэмдэглэсэн. Цогтцэций сум нь 72,5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг мужид багтдаг. Нийслэлээс 540км, аймгийн төвөөс 100км зайд оршдог. Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдтай, Дундговь аймгийн Өлзийт сумтай тус тус хиллэн, далайн түвшнээс 1200-1791м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна.
Уур амьсгалын нөхцөл	Өмнөговь аймгийн Цогтцэцийсумын нутгаар агаарын дундаж температур 3.9-6.1°C байх ба 1-р сарын температур -11.5°C, 7-р сард 20.2°C орчим байдаг. Хур тунадасны хуваарилтийн хувьд хуурай, гандуу бүс нутагт багтах бөгөөд жилд унах хур тунадасны хэмжээ төсөл хэрэгжих талбайд дундажаар 102.0 мм орчимд хэлбэлздэг. Уулс хоорондын хөндийн системд байрладаг учираас салхины хурд 2.6- 3.4м/сек, орчимд шороон шуургатай өдрийн тоо жилд 20 орчим байдаг
Агаар, дуу чимээ	Судалгааны талбайд 2024 оны 7 сарын 10-ны өдөр хийж гүйцэтгэсэн дуу чимээний хээрийн хэмжилт судалгаагаар MNS4585:2017-ийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давж ажиглагдсан. Энэ нь судалгааны талбай нь авто зам дагуу байрладаг ба энэ орчимд авто замын хөдөлгөөнд оролцох машин, мотоциклын дуу чимээ, байгалийн гаралтай хүчтэй салхитай байсантай холбоотой. Мөн судалгааны талбайн ойр орчмын агаарын чанарыг тодорхойлохдоо Өлгий сумын цаг уурын харуулын 7 сарын орчны шинжилгээний өгөгдлийг ашигласан. Судалгааны талбай ормын агаарын чанарын мэдээнээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн (SO ₂) 20 минутын дундаж агууламж болон азотын давхар ислийн дундаж агууламжууд тус тус зөвшөөрөгдөх дээд хэмжээнд буюу MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.
Ус	Судалгаанд хамрагдаж буй талбай нь Говийн их мужид, далайн түвшнээс дээш 1200-1500 м-ийн өндөрт орших бүс нутагт багтах ба ус зүйн хувьд тус бүс нутаг нь төв Азийн гадагш урсацгүй ай сав газарт оршиж байна. Монгол орны уруйн үер дунд зэрэг болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон хур борооны улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой. Усны гадаргаас уурших ууршил 200 см/жил хүртэл байдаг бол ууршиц 80 см/жил-ээс их байна. Энэ нь тус бүс нутаг гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага, харин уурших боломжит хэмжээ манай орны хувьд хамгийн их байдаг нутаг юм. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 115-150 мм/ жил, үүнээс дулааны улиралд 100 мм буюу түүнээс бага, зөвхөн зарим хэсэгт 100-150



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

	<p>мм, өвлийн улиралд 10 мм-ээс бага хур тунадас тус тус унана. Судалгаанд хамрагдсан бүс нутаг маань гадаргын усны хувьд маш бага судлагдсан, байнгын ажиглалт хэмжилтийн цэг сүлжээгүй бөгөөд ус зүйн аливаа тооцоо, судалгаанд шаардлагатай мэдээ, материал маш хязгаарлагдмал юм. Тус бүс нутагт байнгын урсац гол горхи байхгүй, түр зуурын урсацтай бүсэд хамаарна. Зөвхөн эрчимжил ихтэй хур борооны үед бага зэргийн гадаргын урсац хуурай сайруудаар үүсэх нөхцөлтэй тул газар нутгийн гадаргын урсац уур амьсгалын хүчин зүйлс ялангуяа хур тунадасны хэмжээ, эрчимжил, хөрсний бүтэц, түүний нэвчилтийн багтаамж, чадавхаас ихээхэн хамаарна. Энэ бүс нутагт ил задгай уснаас жилдээ ойролцоогоор 1000-1500 мм ус ууршина. Урсцын модуль ба газар орны өндрийн хамаарлаас үзвэл Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтах Говийн нутгийн түр зуурын урсацтай бүсэд гадаргын урсац 0.02-оос 0.05 л/сек км² хооронд хэлбэлзэх нөхцөлтэй болно.</p>
Хөрс	<p>Төсөл хэрэгжих талбай нь хөрс-газарзүйн мужлалтаар Төв Азийн био-уур амьсгалын Говийн их мужийн өргөрөгийн бүсшилийн хэв шинж бүхий цөлжүү цөлийн бор хөрсний 8-р тойргийн нутагт хамрагдана. Тус тойргийн хэмжээнд говийн хажуугийн элэгдэл- эвдрэлийн хэв шинж бүхий нам уулс бүхий нутгаар сайр чулуурхаг, нимгэн үе давхаргатай, сул хөгжилтэй цайвар хүрэн болон цайвар бор хөрс, уул хоорондын хотос, хөндийгөөр заримдаг цөлийн цайвар бор хөрс өргөн тархалттай байдаг. Хөндийн ёроол болон хотос, хонхор газруудаар ойр орчмын өндөрлөг газраас хур борооны үерийн усаар зөөгдөж буусан шал хөрс, мараалаг, хужирлаг хөрс толбо байдлаар тохиолдоно [БНМАУ-ын Үндэсний Атлас, 1990].</p> <p>Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ШТС нь сумын төвд байрлах бөгөөд өргөрөгийн бүсшил бүхий хээржүү цөлийн 8-р тойрогт багтах учир зонхилох хөрсөн бүрхэвч нь заримдаг цөлийн цайвар бор хөрс, түүний дэд хэв шинж болох цөлөрхөг хээрийн бор хөрс, техноген нөлөөлөлд говийн бор хөрсний хэв шинж зонхилон тархана. Тухайн нутагт хөрс үүсгэгч эх чулуулаг нь гол төлөв дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэй, хөрсний үе давхаргад сайр чулууны агууламж ихтэй, карбонаын агууламж илрэх гүн жигд биш делюви, пролювийн болон элювийн гаралтай сэвсгэр хурдсаас голлон тогтсон байна. Говь, цөлийн бүсийн ландшафтийн нам уулс, долгиот талын төрх байдалтай уялдан сайр чулуурхаг, нимгэн үе давхаргатай, сул хөгжилтэй цайвар хүрэн болон цайвар бор хөрс өргөн тархалттай байдаг. Уулнаас буусан үерээр үүссэн хуурай сайраар сайрын элсэнцэр хөрс тархах бол хотос хонхор газруудаар хужир, мараалаг хэлбэрийн хөрс элбэг тохиолдоно [БНМАУ-ын Үндэсний Атлас, 1990].</p>
Ургамал	<p>Өмнөговь аймгийн Цогтцэций сум нь ургамал- газарзүйн мужлалтаар хуурай хэв шинжийн Говь–Гурван сайханы тойргийн бүс нутагт байрлана. Тус бүс нутагт Таана, хөмөл, харгана, бударгана зэрэг хуурайдуу цөлийн хэв шинжийн ургамал зонхилно. Төслийн үйл ажиллагааны улмаас ойр орчмын талбай ихээхэн талхагдалд өртөж, ургамал бүрхэвч устсан шинжтэй байна.</p>
Амьтан	<p>Судалгааны талбайн амьтдын судалгааны хээрийн хэмжилтийн үед хот газрын шувууд тохиолдсон. Төслийн талбайн ойр орчмын нутаг нь суурин газар учир , хүн амын төвлөрөл, машин механизмын хөдөлгөөн зэргээс үүдэн энэ орчимд томоохон зэрлэг амьтад тааралдахгүй, харин хот газрын нохой шувууд тохиолдох боломжтой юм.</p>



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

<p>Тусгай хамгаалалттай газар нутаг</p>	<p>Судалгааны талбай орчмын улсын болон орон нутгийн ТХГН-ийн судалгааг өмнө нь хийгдэж байсан суурь судалгаа, мэдээ мэдээлэл болон Монгол улсын ТХГН-ийн мэдээллийн санд байршуулсан орон зайн мэдээ, мэдээллийн тусламжтайгаар хийж гүйцэтсэн. Үүний үр дүнд бидний судалгааны талбай буюу нефтийн агуулах болон ШТС-аас хамгийн ойр орших орон нутгийн ТХГН нь зүүн-хойд зүгт 10.3 км зайд орших “Бугын голын урд хойд хөндий” нэртэй сумын ОНТХГН байна. Тус сумын ОНТХГН-ийг 2003 оны 4 сарын 13-ны өдөр сумын орон нутгийн тусгай хамгаалттай газар нутаг болгохоор шийдвэрлэжээ. Мөн төслийн талбай байрлах Өлгий суманд улсын тусгай хамгаалалт бүхий газар байдаг ба төслийн талбайгаас баруун – өмнө зүгт 86.5 км зайд орших “Алтай таван богд” байгалийн цогцолбор газар юм. Уг улсын тусгай хамгаалалт бүхий газар нь Баян-Өлгий аймгийн Улаанхус, Цэнгэл, Өлгий , Алтай сумдын нутгийн баруун талын улсын хил дагуу байрласан газрыг хамардаг бөгөөд 1996 оны 5 сарын 28-ны өдөр УИХ-ын 43-р тогтоолоор тусгай хамгаалалтад авсан.</p>
---	---



БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

4.1. УУР АМЬСГАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛСЭЭС ҮҮСЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Төслийн үйл ажиллагаанд уур амьсгалын дараах хүчин зүйлсийг тооцоогүйгээс Газрын тосны агуулах газрын тос, түүний бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, ачих үед сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:

- Гаднах агаарын тооцооны температур /хамгийн хүйтэн хоног, салхивчны тооцоо, хамгийн халуун үе/
- Ул хөрсний хөлдөлт, гэсэлтийн нормативд гүн /хөрсний шаварлаг, элсэнцэр, жижиг ширхэгт элсэн хөрс, том ширхэгт элсэн хөрс, хэвтээ гадарга дээрх цасны ачаалал/
- Салхины тооцооны их хурд /1-10 жилийн салхины тооцооны хурд/
- Салхины шахац /1-5жил/

4.2. АГААРЫН ЧАНАРЫН ХҮЧИН ЗҮЙЛСЭЭС ҮҮСЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Агуулахын үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх голлох сөрөг нөлөөллийг нефтийн бүтээгдэхүүний ууршилт болон автомашины хөдөлгүүрээс ялгарах утаан дахь хорт нэгдлүүд үүснэ. Ууршсанаар нүүрстөрөгч, хүхрийн нэгдлүүд, азотын нэгдлүүд дэгдэх хэт халуун агаарт шаталт үүсгэх, дизель түлш, бензиний уур ялангуяа алкендууд алдагдах зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх ба агаар дахь хүчилтөрөгчийн хэмжээг багасгах, нүүрсхүчлийн болон хүхэрт устөрөгчийн, аммиакийн хэмжээг эрс ихэсгэхэд хүргэнэ.

Нефтийн бүтээгдэхүүний ууршилт: Агуулахын үйл ажиллагааны явцад хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь нефтийн бүтээгдэхүүний ууршилт юм.

Нефтийн бүтээгдэхүүний ууршилт нь шингэний гадаргуугаас уур үүсэх процесс бөгөөд өөрөөр хэлбэл шингэнээс уурын фазад шилжих үйл явц юм. Нефтийн бүтээгдэхүүний ууршилтын процесс нь нийлмэл процесс бөгөөд найрлага дахь нүүрстөрөгчид нь тодорхой дарааллаар ууршилтад ордог байна. Ууршилтыг дотор нь статик, динамик гэж ангилж үзэж болно.

Ууршиж буй шингэн ба хүрээлэн байгаа орчин нь бие биетэйгээ харьцангуй хөдөлгөөнгүй байгаа нөхцөлд явагдах ууршилтыг статик ууршилт гэх бөгөөд харин хөдөлгөөнтэй байгаа нөхцөлд явагдах ууршилтыг динамик ууршилт гэнэ. Статик ууршилтыг нефть ба нефтийн бүтээгдэхүүний хадгалалтын үед явагдах ууршилтаар төлөөлөн авч үзэж болох бол динамик ууршилтыг нефтийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх болон борлуулах үеийн гэж үзэж болно.

Нефтийн бүтээгдэхүүний ууршилт нь агаар ба дулаан солилцлын нөхцөл, агаар дахь уурын диффузын коэффициент, ханасан уурын даралт гэх мэт олон хүчин зүйлсээс хамаардаг. Бүх төрлийн нефтийн бүтээгдэхүүн нь хадгалалт ба ашиглалтын үед тодорхой хэмжээгээр ууршдаг байна. Иймд нефтийн бүтээгдэхүүний ууршилтын хэмжээг Монгол улсад мөрдөж байгаа нефтийн



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

бүтээгдэхүүний хэвийн хорогдлын нормыг тооцох журмын дагуу тодорхойлж байх шаардлагатай.

Агаарт дэгдэх нэгдлүүд, хүлцэх агууламж: Нефтийн бүтээгдэхүүн агаарт ууршихад хүний биед хортой олон тооны дэгдэмхий бодисууд ялгаруулдаг ба хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хүний биед сөрөг нөлөөллүүдийг үзүүлдэг байна. Агаарт бензиний уур 0.03% болсон үеэс хүн мэдэрч эхлэх ба ийм агаараар хүн удаан амьсгалбал мэдрэлийн олон хэлбэрийн гэмтэл, булчин сулрах, ядрах, эцэж турах, хоолонд муудах зэргээр өвчилнө. Хэрэв агаарт бензиний уур 0.07-0.28% хүртэл хүн 15 минутад, 1.15-2.20% хүртэл 3 минут 2.2%-иас дээш гарвал 10-22 секундэд хордож цаашилбал үхэлд хүргэх аюултай байдаг байна.

Нефтийн бүтээгдэхүүнд байдаг зарим нэгдлүүдийн үзүүлэх нөлөөллийг дурдъя. Үүнд:

- **Нүүрстөрөгчид** Нефтийн бүтээгдэхүүний ууршилтаас үүссэн нүүрстөрөгчийн компонентууд нь юуны өмнө төв мэдрэлийн системийг гэмтээж ялангуяа дунд тархийг гэмтээхээс гадна зүрх судасны системийн үйл ажиллагааг доголдуулж, цусан дахь эритроцит, гемоглобины хэмжээг багасгадаг.
- **Бензин** Энэ нь голчлон төв мэдрэлийн системийг гэмтээх, зүрх судасны үйл ажиллагааг доголдуулахаас гадна элэгний үйл ажиллагаа, организмын иммунобиологийн идэвхийг сааруулна. Бензиний ууршилт $10\text{мг}/\text{м}^3$ болсон үед мэдрэгдэх бөгөөд зөвшөөрөгдөх дээд агууламж нь $1.5\text{мг}/\text{м}^3$ байдаг.
- **Вензол** Энэ нь мансууруулах бодисын төрөлд багтах ба хүний мэдрэлийн систем, цусыг хордуулах агаад их дозоор удаан үйлчилбэл мэдрэл саатах хүртэл нөлөөлөл үзүүлнэ. Хүлцэх агууламж $2.4\text{мг}/\text{м}^3$ байна.
- **Хүхэртүстөрөгч** Энэ нь төв мэдрэлийн системийн гэмтээх үйлчилгээтэй бөгөөд $1000\text{мг}/\text{м}^3$ –ээс дэш агууламжаар үйлчилбэл үхэлд хүргэх аюултай. Агаарт байж болох хүлцэх хэмжээ $0.008\text{мг}/\text{м}^3$ болно.
- **Хүхрийн диоксид** Энэ нь дээд мэдрэлийн системийн гэмтээх үйлчилгээтэй бөгөөд их дозоор төдийгүй бага дозоор удаан амьсгалбал амьсгалын замын эрхтнүүдийг гэмтээнэ. Нэг удаагийн хамгийн дээд агууламж $3\text{мг}/\text{м}^3$, хоногийн зөвшөөрөгдөх дээд агууламжийг $0.085\text{мг}/\text{м}^3$ байхаар нормчилно.
- **Бенз (а) пирен** Энэ нь химийн канцероген бодис юм. Агаарт байж болох хүлцэх дээд хэмжээ нь $0.1\text{мг}/100\text{м}^3$ -ээс бага байх ёстой.

Хүснэгт 3. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ

Бохирдол	Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед	Машин хурдтай явж байх үед ($60\text{км}/\text{цагаас}$ дээш)	Машин тойргоор эргэх үед	Машины хурд саарч байх үед ($60\text{км}/\text{цагаас}$ дээш)
CO (%)	4- 500	< 1-8	1-7	2-9
HC, C ₆ H ₁₄ (ppm)	500-1000	50-80	200-800	3000-12000
NO _x (ppm)		1000-4000	1000-3000	5-5 0



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Агаарт орчны бохирдлыг багасгах чиглэлээр манай оронд сүүлийн үед судалгаа шинжилгээ их хийгдэж байгаа бөгөөд автомашины янданд утаа шүүгч, гүйцээн исэлдүүлэгч тавих талаар бодит алхам гарч байна.



БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг хянах үүрэгтэй.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах "Газрын тосны бүтээгдэхүүний агуулах" төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч төслийн хэрэгжүүлэх нийт хугацаанд энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ГОЛ ШААРДЛАГА

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

БОМТ-г боловсруулахдаа Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" болон "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-г удирдлага болголоо.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Иймд төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 10.040.000 мян.төг юм.

Хүснэгт 4. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа /мян.төг/

№	Ажлын нэр	Зардал
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	7.000.000
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	3.040.000
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ		10.040.000



5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн харуулж буй төсөл хэрэгжүүлэгчийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд ба түүнтэй холбогдох бусад зураг төслийн буюу туслах ажлуудын зардал ороогүй.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн "НИК" ХХК-ийн Өмнөговь аймагт хэрэгжүүлж буй агуулахын төслийн үйл ажиллагаанд зориулагдсан болно. Төслийн хүчин чадал өөрчлөгдөх, нэмэгдэх бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах тул төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрд нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй.

- БОХТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, судалгаа шинжилгээгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх;
- БОХТ-ний биелэлтийг дүгнэхдээ тухайн жилийн хяналт, судалгаа шинжилгээгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх;
- БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 15-ны дотор Өмнөговь аймгийн Байгаль орчны газар, Цогтцэций сумын оршин суугчдад танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

Хүснэгт 5. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал /мян.төг/

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал
1	Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7.000.000
2	Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	1.000.000



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	290.000
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	200.000
8	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	1.050.000
2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал		10.040.000

5.1.1. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгана. Байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)—ээр төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх ерөнхий төлөвлөгөөг тооцож гаргасан удирдах дээд байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 6. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
АГААРЫН ЧАНАР					
Машин техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, (PM10, PM2.5)	ШТС-ын гадаад орчныг зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэх арга хэмжээ (машин техникийн тээвэрлэлт хийх, газрын тосны бүтээгдэхүүнийг буулгах талбайг тэмдэгжүүлэх, гадаад орчныг тохижуулах)	Агуулахын эзэмшлийн талбайг хамран	2026 онд	3.000.000	-MNS 17.5.1.21:1992 Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх түвшин хэмжих арга -Агаарын тухай хууль,
	Талбайн орчимд усалгаа, цэвэрлэгээ хийх, автомашины явалтаар үүссэн тоосонцрыг зайлуулах.	Агуулахын орчимд	2026 онд	500.000	-MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агуулахад ажиллах ажилчдын ахуйн хог хаягдлын буруу хадгалалтаас үүсэх эвгүй үнэр орчинд тархах, амьдрах орчин доройтох зэрэг нөлөөлөл үзүүлж болзошгүй.	Ажилчдын ахуйн хог хаягдлыг зориулалтын сав, стандарт шаардлагад нийцүүлэн барьсан угаадасны нүхэнд цуглуулах, тээвэрлэлт, цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийж байх	Агуулахын орчимд	Хог хаягдлын менежментэд тусгагдсан		-MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ -MNS 4585:2016 Агаарын чанар. Ерөнхий шаардлага -Монголын агаарын чанарын стандарт (MNS)-4585:98, MNS-3384:82, MNS-3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томьёо, тодорхойлолт
Тээвэрт ашиглаж буй машин техник, нефтийн бүтээгдэхүүний буруу хадгалалтаас үүсэж болзошгүй хорт хий	Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтад тогтмол хяналт тавих, Амьсгалах клапанд болон бензин, түлш хадгалах савны битүүмжлэлд улирал бүр хяналт тавьж тохируулга хийх	Энэ чиглэлээр мэргэшсэн засварчин, хяналтын ажилтнаар хийлгэх.	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд	Газрын тосны бүтээгдэхүүний эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.	-MNS 4633 : 2006 Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал
	Дамжуулах хоолойнууд, тэдгээрийн холболтын эд ангиуд болон нээх-хаах хавхлагын битүүмжлэлийг байнга шалгаж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх	Агуулахад ажиллаж буй ажиллагсдад энэ чиглэлийн үүрэг даалгавар өгч байх, ямар нэг зөрчил гарвал удирдах албан тушаалтан, ахлан ажиллаж буй хүнд мэдээлж байх.	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд		
	Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын чанарт шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх	Агуулахын нийт орчинд	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАН ОРЧИН					
Хадгалалтын горим алдагдах буюу тусгайлан бэлтгээгүй талбайд нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах байрлуулах, нефтийн бүтээгдэхүүнийг орчинд алдах улмаар энэ нь байгалийн гамшиг аюул ослын үед хур борооны усаар угаагдах, газрын доорх ус, хөрсөнд алдагдаж болзошгүй.	Агуулахын үйл ажиллагаанд байнга хяналт тавих, нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах талбайд нефтийн бүтээгдэхүүн асгарсан байдалд хяналт тавих	Ажилтан албан хаагчдад энэ талын үүрэг даалгаврыг өгч байх, сургалт зохион байгуулах, самбар гаргах	Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан		<ul style="list-style-type: none"> - MNS 13.060.50 Усны чанарын стандарт - Усны тухай хууль - 2.3.5 хавсралт, - MNS 4943:2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
	Хөрс усанд нефтийн бүтээгдэхүүн нэвчиж болзошгүй хэсгийг засварлаж ажиллах		Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан		
	Нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд саармагжуулах ажлыг зохион байгуулах	Хөрсийг хусаж авах багаж, хүрз, элс, шороо зэргийг бэлдэх	Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан		
Ахуйн бохир ус болон үйл ажиллагааны угаалга цэвэрлэгээнээс гарсан бохир усыг ил задгай асгах зэргээр хөрсний усны чанарт нөлөөлөх	Ахуйн бохир усыг хөрсөнд шууд асгахгүй байх талаар ажилчдад анхааруулж байх		Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан		
	Асгарсан тохиолдолд бохирдсон байдлаас шалтгаалан саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах	Хөрсийг хусаж авах багаж, хүрз, элс, шороо зэргийг бэлдэх	Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан		
	Төслийн талбайд байгуулсан нүхэн жорлонг ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж хэвших, талбайн орчимд бохирдлыг тодорхойлох хяналт, шинжилгээг хийх		БОХШХ-т тусгагдсан.		
ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАЗРЫН ГАДАРГА, УРГАМЛЫН НӨМРӨГ					
Машин механизмын хөдөлгөөн, нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд орох	Тэмдэгжүүлэх /аюулгүй ажиллагааны мэдээллийг хавсаргасан байвал сайн	Агуулахын эзэмшлийн талбай болон түүний орчны 100м-т	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд тусгагдсан.		<ul style="list-style-type: none"> - MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ - MNS 5342:2007 "Автомашин зогсоол, ангилал, ерөнхий шаардлага"
Ахуйн хатуу, шингэн хог хаягдлаар хөрс бохирдох	Ахуйн хатуу, шингэн хог хаягдлын цэгийг холбогдох стандарт, шаардлагад нийцүүлэн засаж тохижуулах		Хог хаягдлын менежментэд тусгагдсан		<ul style="list-style-type: none"> - УСТ 3298-91 Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
Машин механизмын хөдөлгөөн, үүссэн тоос тоосонцор орчинд тархан, хөрсөн дээр бууж, бохирдол үүсгэх	Талбайн цэвэрлэгээ, усалгааг тогтмол хийх, үүсэж буй тоосонцрыг зайлуулах	Агуулахын нийт талбайг хамруулан	Агаар орчныг хамгаалах арга хэмжээнд тусгагдсан		<ul style="list-style-type: none"> - УСТ 328-91



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

<p>Агуулахын аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдал алдагдах зэрэг нь нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд алдагдах, хур бороо, үерийн усаар дамжин хөрсөнд тархах, хөрсний бохирдол үүсгэх</p>	<p>Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.</p>			<p>Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд - MNS 5918-2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын ургамалжуулахад тавигдах шаардлага</p>
АМЬТАН				
<p>Гал, ослын үед дэгдсэн шатамхай нефтийн бүтээгдэхүүний хорт утаа хур тунадсаар дамжин орчны чанарт нөлөөлөх</p>	<p>Болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан</p>			<p>-MNS 5915:2008 Эвдэрсэн газрын ангилал -MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт</p>
<p>Нефтийн бүтээгдэхүүнээс идэх, амьсгалах зэрэг шууд замаар амьтдын аймагт сөргөөр нөлөөлнө</p>	<p>Нефтийн бүтээгдэхүүнийг хадгалах сав ёмкость, Агуулахын байрын битүүмжлэлийг сайжруулах, мэрэгч болон бусад амьтад нэвтрэх боломжийг бууруулах.</p>	<p>Ашиглалтын хугацаанд</p>	<p>2026 онд</p>	<p>3.500.000</p>
<p>2026 оны Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал</p>				<p>7.000.000</p>



**"НИК" ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ "ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ" ТӨСЛИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ**

5.1.2. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө

Газрын тухай хуулийн 56.6. тоотод зааснаар Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана. Тус төслийн талбайн нийт 1 га талбай байна. Үүнээс нийт талбайн 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх ногоон байгууламжтай болгох шаардлагатай.

Монгол улсын барилгын норм дүрэм, ГТБ хадгалах агуулах, Шатахуун түгээх станц, галын аюулгүйн дүрэм БНБД 21-07-14-т эзэмшлийн талбайгаас 10м-ийн зай дотор үр, тариа, хөвөн, хөвөнлөг үр унадаг мод, бут тарихыг хориглоно гэж заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч нь Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль"-ийн 7.2.4-р заалт “..Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх”-ийн дагуу эвдэрсэн газрыг нөхөн сэргээн тохижуулах, талбайн орчимд мод бутыг тарих ажлыг ГТБ агуулахын талбайгаас 10 метрийн зайнаас гадагш хийхэд тохиромжтой.

ГТБ агуулахын орчимд ногоон байгууламжийг байгуулах, сукцесст орсон хэсэгт нөхөн сэргээлт хийхдээ олон наст өвслөг ургамлаар захын хэсгийг эмжээрлэн тарих нь байгууллагын үзэмжид тохиромжтой юм. Учир нь хөвөнлөг үр хаядаггүй өвслөг ургамал тарих галын аюулгүй байдлын дүрэмд тусгагдсан.

Төсөл хэрэгжүүлэгч нь тарьсан олон наст өвслөг ургамал бүхий ногоон байгууламжийн ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, тордлогоор байнга хийх, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах арга хэмжээг цаашид авч ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 7. Ногоон байгууламжийг нөхөн сэргээлтийн хэмжээний төлөвлөгөөний зардал

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Олон наст өвслөг ургамал тарих	Талбайн хөрсийг бордох, хөрсний чанарыг сайжруулах	Ногоон байгуулам-жийн орчимд	100.0 (1 жилд)	400.000	2026 онд
